

## ИХ ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦАХ (D2): КОЛЛЕЖ (D-2-1), БАКЛАВР (D-2-2), МАГИСТР (D-2-3), ДОКТОР (D-2-4)

### ОЛГОХ ХҮРЭЭ:

Коллеж ба түүнээс дээд шатны боловсролын байгууллага эсвэл эрдэм шинжилгээ болон судалгааны байгууллагад суралцах, судалгаа хийх гэж буй иргэн.

Монгол Улсаас БНСУ-д суралцахаар төлөвлөж буй иргэн **Солонгосын Виз Мэдүүлэх Төвөөр** дамжуулан визээ мэдүүлнэ. Та 2 жил хүртлэх хугацаатай нэг удаагийн нэвтрэх эрхтэй виз мэдүүлж болох бөгөөд БНСУ-ын ЭСЯ-аас нэмэлт бичиг баримтууд шаардаж болно. Виз мэдүүлж буй МУ-ын иргэн хамгийн сүүлд төгссөн сургуулийн диплом ба дүнгийн жагсаалтын эх хувийг СВМТ-д өгөх бөгөөд эцсийн шийдвэр гарсан даруйд паспортын хамт буцаан олгогдоно.

### БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (Маягт 17): Цээж зураг (3.5 x 4.5 см хэмжээтэй, сүүлийн 6 сарын дотор авахуулсан) визний хураамж 60 ам.доллар
2. Гадаад паспорт, хуулбарын хамт 1 хувь (Виз мэдүүлж буй өдрөөс хойш хамгийн багадаа 6 сарын хүчинтэй байх)
3. Товч намтар (ЭСЯ-ны маягтын дагуу бөглөх, MS Word, Hangul программ ашиглах, заавал өөрийн гараар гарын үсгээ зурах)
4. Элсэлтийн зөвшөөрлийн гэрчилгээ, Сургуулийн ААН гэрчилгээний хуулбар
5. Сургалтын зардал, санхүүгийн чадвар нотлох бичиг баримт  
Өөрийн эсвэл батлан даагчийн нэр дээрх Монгол дахь банкны дансны тодорхойлолт (Виз мэдүүлэх өдрөөс өмнө 14 хоногийн дотор авсан байх)
  - **Төвийн бүс (Сөүл хот, Инчон хот, Гёнги аймаг)-ийн сургуулиудын оюутнууд:**  
Сүүлийн нэг сарын турш 20000 ам.доллар байршуулсан байх (30 хоногоос доош орохгүй байх)
  - **Бусад бүсийн сургуулиудын оюутнууд:**  
Сүүлийн нэг сарын турш 18000 ам.доллар байршуулсан байх. (30 хоногоос доош орохгүй байх)
  - Дансанд байршуулсан мөнгөн дүн нь виз мэдүүлэх өдрийг хүртэл нэг сар болон түүнээс дээш хугацаанд хөдөлгөөнгүй байх ба виз мэдүүлгийг шалгаж дуусах хүртэл заасан доод хэмжээнээс буухгүй байх.
  - Эхнэр/нөхөр батлан даах боломжгүй. (Зөвхөн БНСУ-д хууль ёсны дагуу ажиллаж амьдардаг тохиолдолд болно.)
- \* Солонгосд амьдрах зардалыг батлан даах
  - Батлан даагч 1, 2:
  - Батлан даагчийн иргэний үнэмлэхийн хуулбар болон төрөл садангийн лавалгаа
  - Гадаадад суралцах зардлын даана гэсэн гар өргөдөл, ажлын газрын тодорхойлолт
  - Батлан даагчийн сарын орлогыг нотлох бичиг баримт (Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар болон лавлагаа, татварын тодорхойлолт г.м)
6. Гэрлэлтийн лавлагаа (сүүлийн 45 хоногт олгогдсон байх)  
19 нас хүрээгүй иргэний хувьд төрсний бүртгэлийн лавлагаа авах бөгөөд төрсний бүртгэлийн лавлагаа дээр эцэг цэхийн төрсөн он сар өдөр тэмдэглэгдээгүй тохиолдолд эцэг эхийн иргэний үнэмлэхний хуулбар авчрах.  
\*Гэрлэлтээ батлуулаагүй хүүхэдтэй иргэний хувьд хүүхдийн төрсний бүртгэлийн лавлагаа нэмэлтээр авах.
7. Цагдаагийн газрын тодорхойлолт (Анх удаа виз мэдүүлж байгаа тохиолдолд, Сүүлийн 45 хоногт олгогдсон байх)
8. Сүрьеэгийн шинжилгээ: (БНСУ-ын ЭСЯ-аас зөвшөөрөгдсөн эмнэлгээс авсан байх)

**9. Хамгийн сүүлд төгссөн сургуулийн гэрчилгээ, диплом, дүнгийн жагсаалтын эх хувь \*\*\***

- Одоо сурч байгаа болон чөлөөтэй буюу завсарласан байгаа оюутнууд: Ахлах сургууль төгссөн гэрчилгээ, их сургуульд сурч байгаа нь үнэн гэсэн тодорхойлолт, өмнөх жилийн дүнгийн жагсаалт.

**10. Хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт:**

Солонгос хэл – Коллеж/МСҮТ: ТОPIK 3-р түвшин/ Сэжун хагдан сургалтын төвийн 5-р түвшин (Дунд 1)

Солонгос хэл – Их, дээд Сургууль: ТОPIK 4-р түвшин/ Сэжун хагдан сургалтын төвийн 6-р түвшин (Дунд 2)

Англи хэл: TOEFL 530 (CBT 197, IBT 71), IELTS 5.5, CEFR B2, TEPS600